




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3556 СЯА АМ.ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
11%



НИЙТ ХАДГАЛАМЖ
15.4 ИХ НАЯД ТӨГ



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
30.4 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
987.2 ТЭРБУМ ТӨГ



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
9%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **2.1%**,

Инфляци: 2020 онд: **6.6%**,

Урсгал тэнцэл: 2020 онд: **-13%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны 4-р сарын тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **-1%**

Инфляци: 2020 онд: **5.6%**,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: **-10.2%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 6-р сарын байдлаар (2198) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 332.3 хувь, зарлага 597.9 хувиар нэмэгдсэн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2198 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 519 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 19.01 төгрөгөөр өсөв.

Зургаадугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 161.79 төгрөг буюу 3.82 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 19.01 төгрөг буюу 0.68 хувиар, өмнөх улирлаас 1.71 хувиар өсч 2816.26 төгрөг болов. 6-р сард гадаад валютын нөөц 3.55 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 11 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 13.3 хувиар, оны эхнээс 18 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 2.8%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 6-р сарын байдлаар өмнөх сараас 0.3 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар, оны эхнээс 2.7 хувь өсөв. Үүнд хүнсний бараа, согтууруулах бус ундаа, хувцас, бөс бараа, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний өссөн нь голлон нөлөөлжээ.



Гадаад худалдааны тэнцэл 368 сая.ам долларын ашигтай гарав.

2020 оны зургаадугаар сард нийт барааны эргэлт 5288 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 28.2, импорт өмнөх оны мөн үеэс 14.99 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 368 сая ам.долларын ашигтай гарав.



6-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: www.mongolbank.mn

Нийт хадгаламж 2020 оны 06-р сард 15.4 их наяд төгрөг болж өмнөх сараас 745.5 тэрбум төгрөг буюу 5.1 хувиар нэмэгдэв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 11.1 хувиар буюу 1539.3 тэрбум төгрөгөөр өсөв. Тус сард төгрөгийн хадгаламж 11054.2 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 3.4 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 4354.3 тэрбум төгрөг болж өмнөх сараас 9.5 хувиар нэмэгджээ. Үүнээс төгрөгийн хадгаламж 72 хувь, валютын хадгаламж 28 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 1.1 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 48.5 хувийг эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ

БОДЛОГЫН ХҮҮГ ХЭВЭЭР ХАДГАЛАХ ШИЙДВЭР ГАРАВ.

- Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдлыг харгалзан үзээд бодлогын хүүг хэвээр буюу 9 хувьд хадгалахаар тогтжээ. Түүнчлэн банкны системийн тогтвортой байдлыг хангах үүднээс банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банкинд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэр гаргасан байна.

ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН ГАРАВ.

- Бизнесийн төлөөллийн байгууллага МҮХАҮТ Монголбанкт хамтран “Инфляцын хүлээлт” түүвэр судалгааг иргэд болон ААН-үүдийн дунд явуулжээ. Судалгааны гол үр дүнг танилцуулбал, ААН-үүд инфляцын түвшинг тоон хариултын хувьд 2020 оны III улиралд 5.6 хувь, II улиралд 6.4 хувь байхаар тус тус хүлээж байна, харин ААН-үүдийн чанарын болон мэдрэмж (үнийн өсөлтийг мэдэрч буй байдал)-д суурилсан инфляцын хүлээлтийн хувьд 2020 оны III улирал болон 2021 оны II улиралд инфляцыг тэг хувийн орчимд буюу үнийн өсөлт харьцангуй тогтвортой байхаар хүлээж байна гэж гарчээ.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 6-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 6-р сар 2020 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn.